БАТЛАВ:

ЗАСАГ ДАРГА Н.ОРХОНТУУЛ

2026 оны 02 сарын 13-ны өдөр

АЖЛЫН ДААЛГАВАР

“Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан, Хархорин сумдын тархан ургаж байгаа хушин ойн өнөөгийн төлөв байдалд үнэлгээ өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх” ажлыг гүйцэтгэх

Нэг. Ажлын гүйцэтгэх болсон үндэслэл

Сүүлийн жилүүдэд ажилгүйдэл их, амьжиргааны түвшин доогуур байгаатай холбоотой ард иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагууд хуш модны самрыг хуулийн дагуу болон хууль бусаар бэлтгэх нь эрчимжиж байгаа тул эмзэг тогтоц бүхий экологийн өндөр ач холбогдолтой хушин ойн экосистемд сөрөг нөлөө үзүүлж буй үндсэн хүчин зүйлүүдийн нэг нь хүний үйл ажиллагааны сөрөг үр дагавар болж байна.

Хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх зөвшөөрлийг 2014 оноос Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар олгож эхэлснээс хойш хушин ойд хүний үзүүлэх сөрөг нөлөөлөл эрчимжсэн.

Иймд хушин ойн сангийн төлөв байдалд үнэлгээ өгөх, хамгаалах, нөхөн сэргээхэд тулгамдаж буй асуудлыг судлах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах зайлшгүй шаардлагатай болж байна.

Хоёр. Ажлын даалгаврын зорилго

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан, Хархорин сумдад тархан ургаж байгаа нийт 20404 га хушин ойн өнөөгийн төлөв байдалд үнэлгээ өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх ажлын зорилго нь хушин ойн сангийн төлөв байдалд үнэлгээ өгөх, хамгаалах, нөхөн сэргээхэд тулгамдаж буй асуудлыг судлах, цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Scanned with CamScanner

Гурав. Гүйцэтгэх ажил

1. Хушин ойн тархалт талбай, нөөцөд үнэлгээ өгөх, /сүүлийн 13 жил/,

   - Хушин ойн тархалтын талбай, нөөцийн хэмжээг аймаг, сумдын хэмжээнд ой зохион байгуулалтын материал болон ойн тооллогын материал ашиглан гаргана.
   - Сүүлийн 13 жилийн хугацаанд хушин ойн талбай, нөөцийн хэмжээнд гарсан өөрчлөлтийг гаргаж, үнэлгээ өгч, дүгнэлт гаргана.
   - Хушин ойн доройтсон, хомсодсон шалтгаан нөхцөлийг тодорхойлно.

2. Хушин ойн ашиглалт, хамгаалал, нөхөн сэргээлтийн өнөөгийн байдлыг тодорхойлох,
   - Хуш модны ашиглалтын өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч цаашдын чиг хандлагыг тодорхойлно.
   - Хушны самрын ашиглалтын өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч цаашдын чиг хандлагыг тодорхойлно.
   - Хушин ойн хамгааллын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч цаашдын чиг хандлагыг тодорхойлно.
   - Хушин ойн байгалийн сэргэн ургалтын өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч цаашдын чиг хандлагыг тодорхойлно.
   - Хушин ойг зориудаар нөхөн сэргээж буй өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч цаашдын чиг хандлагыг тодорхойлно.

3. Хушин ойн өнөөгийн төлөв байдалд дүгнэлт гаргах,

   - Хушин ойн тогтвортой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн талаарх бодлого, хууль, эрх зүйн орчны өнөөгийн байлалд үнэлгээ өгч цаашдын чиг хандлагыг тодорхойлно.
   - Хуш модны улаан дансны үнэлгээг хийж, хушин ойн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлно.

4. Хушин ойн талаар цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах.

   - Монгол орны хушин ойг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх талаар санал, дүгнэлт боловсруулж, гаргана.

Дөрөв. Ажлын үе шат:

Scanned with CamScanner

№	Үйл ажиллагаа	Хугацаа
1	Хушин ойн тархалт талбай, нөөцөд үнэлгээ өгөх, /сүүлийн 13 жил/;	2026 оны 04 сарын 01-ээс 2026 оны 06 сарын 15
2	Хушин ойн ашиглалт, хамгаалал, нөхөн сэргээлтийн өнөөгийн байдлыг тодорхойлох;	2026 оны 06 сарын 29-ний дотор
3	Хушин ойн өнөөгийн төлөв байдалд дүгнэлт гаргах;	2026 оны 07 сарын 01-ний дотор
4	Хушин ойн талаар цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах;	2026 оны 09 сарын 15-ны дотор
5	Ажил гүйцэтгэсэн тайланг файл болон цаасан хэлбэрээр 3 хувь үйлдэж, захиалагчид ирүүлэх	2026 оны 10 сарын 15-ны дотор

Тав. Хүрэх үр дүн

Энэхүү ажлыг гүйцэтгэснээр дараах үр дүнгүүд гарсан байна.Үүнд:

1. Өвөрхангай аймагт тархан ургаж байгаа хушин ойн өнөөгийн төлөв байдалд үнэлгээ өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх ажлын зорилго нь хушин ойн сангийн төлөв байдалд үнэлгээ өгөх, хамгаалах, нөхөн сэргээхэд тулгамдаж буй асуудлыг судлах, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж гарсан байна.

2. Дэлгэрэнгүй тайлан гарсан байна.

БОЛОВСРУУЛСАН: СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН

ИНЖЕНЕР А.МЯГМАРДАГВА

ХЯНАСАН: ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

ОЙН ИНЖЕНЕР Ш.БУМАНДОЛГОР

Scanned with CamScanner